| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                                      | <b>370,862,000.00</b>   | <b>368,049,912.75</b>   |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 76,593,900.00           | 49,378,032.35           |
| 210302      | Түлш, халаалт   | 292,630,100.00          | 317,866,880.40          |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 1,638,000.00            | 805,000.00              |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>29,161,200.00</b>    | <b>25,373,555.00</b>    |
| 210401      | Бичиг хэрэг   | 4,276,600.00            | 3,001,450.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 19,217,500.00           | 16,637,105.00           |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 3,130,100.00            | 2,068,000.00            |
| 210404      | Ном, хэвлэл   | 178,200.00              | -                       |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                             | 854,500.00              | 2,626,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 1,504,300.00            | 1,041,000.00            |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>858,900.00</b>       | <b>850,000.00</b>       |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 858,900.00              | 850,000.00              |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>36,063,000.00</b>    | <b>28,062,200.00</b>    |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 11,934,900.00           | 10,957,700.00           |
| 210604      | Урсгал засвар   | 24,128,100.00           | 17,104,500.00           |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | <b>17,345,500.00</b>    | <b>16,170,000.00</b>    |
| 210702      | Дотоод албан томилолт   | 17,345,500.00           | 16,170,000.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                       | <b>10,558,700.00</b>    | <b>8,583,353.00</b>     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                  | 772,700.00              | 445,500.00              |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 975,000.00              | 756,000.00              |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 309,000.00              | 115,830.00              |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | 900,000.00              | 831,051.00              |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 212,000.00              | -                       |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 5,901,000.00            | 5,150,000.00            |
| 210807      | Газрын төлбөр   | 1,489,000.00            | 1,284,972.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>94,146,000.00</b>    | <b>72,279,410.00</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 87,860,400.00           | 68,641,910.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 6,285,600.00            | 3,637,500.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>21,348,700.00</b>    | <b>20,915,000.00</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>21,348,700.00</b>    | <b>20,915,000.00</b>    |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,260,000.00            | 7,095,000.00            |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 14,088,700.00           | 13,820,000.00           |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>482,843,900.00</b>   | <b>373,969,772.00</b>   |
| 223001      | Бусад хөрөнгө   | 482,843,900.00          | 373,969,772.00          |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>                                     | <b>152,637,000.00</b>   | <b>60,000,000.00</b>    |
| 230001      | Эргэж төлөгдөх зээл   | 152,637,000.00          | 60,000,000.00           |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>1,930,309,600.00</b> | <b>1,940,562,411.96</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>  | <b>171,840,000.00</b>   | <b>169,103,868.00</b>   |
| 310004      | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих                                       | 171,840,000.00          | 169,103,868.00          |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>   | <b>1,664,494,600.00</b> | <b>1,681,956,706.45</b> |
| 320001      | Орон нутгийн төсвөөс  | 1,664,494,600.00        | 1,681,956,706.45        |

|        |  |                         |                         |
|--------|--|-------------------------|-------------------------|
| 35     | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | 93,975,000.00           | 89,501,837.51           |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 93,975,000.00           | 89,501,837.51           |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                            |                         |                         |
| 8      | <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>                        | <b>420,954,900.00</b>   | <b>(136,818,365.25)</b> |
| 9      | <b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                  | <b>(420,954,900.00)</b> | <b>136,818,365.25</b>   |
| 7      | <b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b> | <b>(420,954,900.00)</b> | <b>136,818,365.25</b>   |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -                       | 459,305,132.23          |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -                       | 322,486,766.98          |

## 2.6. Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

|            |  | <i>/төгрөгөөр/</i>   |
|------------|--|----------------------|
| Дансны код | Дансны нэр, төрөл  | Тайлант он           |
| 1          | <b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>  | <b>23,311,322.00</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>23,311,322.00</b> |
| 122        | Тусламжийн орлого  | 23,311,322.00        |
| 1221       | Хандив тусламж /дотоод/  | 23,311,322.00        |
| 12213      | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>23,311,322.00</b> |
| 350014     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,390,000.00        |
| 350015     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 2,921,322.00         |
| II         | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>23,083,627.82</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>23,083,627.82</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>23,083,627.82</b> |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>2,807,809.00</b>  |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 2,807,809.00         |
| 2105       | <b>Нормативт зардал</b>  | <b>770,000.00</b>    |
| 210502     | Хоол, хүнс   | 770,000.00           |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>700,000.00</b>    |
| 210601     | Багаж, техник, хэрэгсэл  | 700,000.00           |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>15,849,705.82</b> |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 15,849,705.82        |
| 2109       | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>2,956,113.00</b>  |
| 210901     | Бараа үйлчилгээний бусад зардал  | 2,956,113.00         |
| 4          | <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>  | <b>227,694.18</b>    |
| 5          | <b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>(227,694.18)</b>  |
| 6          | <b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>   | <b>(227,694.18)</b>  |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг чанд сахиж иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 176.3 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | /сая төгрөгөөр/ |                 |               |
|--|-----------------|-----------------|---------------|
|  | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт      |
| Б  | 1               | 2               | 3=2-1         |
| Мөнгөн хөрөнгө                               | 459.3           | 322.5           | -136.8        |
| Авлага                                       | 202.0           | 227.4           | 25.4          |
| Бараа материал                               | 257.1           | 300.7           | 43.6          |
| Үндсэн хөрөнгө                               | 2,181.0         | 2,072.4         | -108.6        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>3,099.4</b>  | <b>2,923.1</b>  | <b>-176.3</b> |
| Өр төлбөр                                    | 15.1            | 115.8           | 100.7         |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 3,084.3         | 2,807.3         | -277.0        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>3,099.4</b>  | <b>2,923.1</b>  | <b>-176.3</b> |

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 322.5 сая төгрөг болж, өмнөх оноос 136.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт                   | /сая төгрөгөөр/ |                 |                        |
|----------------------------|-----------------|-----------------|------------------------|
|                            | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Кассад байгаа бэлэн мөнгө  | -               | -               | -                      |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 459.3           | 322.5           | -136.8                 |
| Төгрөг                     | 459.3           | 322.5           | -136.8                 |
| Төрийн сангийн харилцах    | 459.3           | 322.5           | -136.8                 |
| <b>Дүн</b>                 | <b>459.3</b>    | <b>322.5</b>    | <b>-136.8</b>          |

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 322.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 111.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 108.3 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 103.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 227.4 сая төгрөг болж, өмнөх оноос 25.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт                      | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|-------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Ажилчидтай холбогдсон авлага  | 0.5            | 0.8             | 0.3                       |
| Зээлийн авлага                | 172.0          | 179.5           | 7.5                       |
| Бусад авлага                  | -              | -               | -                         |
| Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ | -              | -               | -                         |
| Байгууллагаас авах авлага     | 0.1            | 18.6            | 18.5                      |
| Хувь хүмүүсээс авах авлага    | 29.5           | 28.5            | -1.0                      |
| <b>Дүн</b>                    | <b>202.0</b>   | <b>227.4</b>    | <b>25.4</b>               |

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын үлдэгдэл өсөхөд Орон нутгийн хөгжлийн сангийн хийгдээгүй ажлын авлага 5.0 сая төгрөг, сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 7.0 сая төгрөг, Сум дундын Ойн ангийн байгууллагаас авах авлага 13.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 300.7 сая төгрөг болж, өмнөх оноос 43.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт                   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|----------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Бичиг хэргийн материал     | 2.4            | 2.1             | -0.3                      |
| Аж ахуйн материал          | 66.3           | 67.4            | 1.1                       |
| Сэлбэг хэрэгсэл            | 1.0            | 0.0             | -1.0                      |
| Барилгын засварын материал | 0.1            | 0.1             | 0.0                       |
| Бусад хангамжийн материал  | 175.3          | 219.2           | 43.9                      |
| Мал амьтад                 | 11.9           | 11.9            | 0                         |
| <b>Дүн</b>                 | <b>257.1</b>   | <b>300.7</b>    | <b>43.6</b>               |

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэл өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,072.4 сая төгрөг болж, өмнөх оноос 108.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт                       | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|--------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Барилга, байгууламж, орон сууц | 1,886.8        | 1,967.1         | 80.3                      |
| Хуримтлагдсан элэгдэл          | -824.9         | -889.8          | -64.9                     |
| Авто тээврийн хэрэгсэл         | 645.9          | 594.2           | -51.7                     |

|                                   |         |         |        |
|-----------------------------------|---------|---------|--------|
| Хуримтлагдсан элэгдэл             | -194.2  | -213.3  | -19.1  |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 710.1   | 718.8   | 8.7    |
| Хуримтлагдсан элэгдэл             | -465.1  | -529.3  | -64.2  |
| Тавилга, аж ахуйн эд хогшил       | 81.2    | 75.7    | -5.5   |
| Хуримтлагдсан элэгдэл             | -51.8   | -56.7   | -4.9   |
| Зам, гүрийн байгууламж            | 77.8    | 126.0   | 48.2   |
| Хуримтлагдсан элэгдэл             | 0       | -3.9    | -3.9   |
| Бусад үндсэн хөрөнгө              | 346.0   | 346.0   | 0.0    |
| Хуримтлагдсан элэгдэл             | -172.3  | -199.9  | -27.6  |
| Программ хангамж                  | 3.8     | 8.8     | 5.0    |
| Хуримтлагдсан элэгдэл             | -3.2    | -4.6    | -1.4   |
| Бусад биет бус хөрөнгө            | 140.9   | 140.9   | 0.00   |
| Хуримтлагдсан элэгдэл             | 0.0     | -7.6    | -7.6   |
| Дүн                               | 2,180.1 | 2,072.4 | -108.6 |

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,072.4 сая төгрөг болж 108.6 сая төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл 51.7 сая төгрөг, тавилга эд хогшил 5.5 сая төгрөгөөр тус тус буурч, тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 115.8 сая төгрөг болж, өмнөх оноос 100.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|----------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Ажилтнуудтай холбоотой өглөг     | 9.8            | 1.5             | -8.3                      |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0            | 1.2             | 1.2                       |
| Байгууллагад төлөх өглөг         | 4.8            | 113.1           | 108.3                     |
| Хувь хүмүүст төлөх өглөг         | 0.5            | 0.0             | -0.5                      |
| Дүн                              | <b>15.1</b>    | <b>115.8</b>    | <b>100.7</b>              |

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 115.8 сая төгрөг болж 100.7 сая төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сан 46.4 сая төгрөг, Байгаль хамгаалах сан 4.9 сая төгрөг, Сум дундын ойн анги 9.5 сая төгрөг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1.6 сая төгрөг, Засаг даргын тамгын газар 12.9 сая төгрөг, болон халаалтын зардлын өртэй байгууллагууд болох Ерөнхий боловсролын сургууль 24.2 сая төгрөг, Цэцэрлэг 7.0 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 9.2 сая төгрөгөөр тус тус өртэй гарсан байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,807.3 сая төгрөг болж, өмнөх оноос 277.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|---|----------------|-----------------|---------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 773.7          | 773.7           | 0.00                      |
| Өмч /төрийн/  | -              | -               | -                         |
| Эздийн өмчийн бусад хэсэг   | -              | -               | -                         |

|                                  |                |                |               |
|----------------------------------|----------------|----------------|---------------|
| <b>Хуримтлагдсан үр дүн</b>      | 1,999.8        | 1,722.8        | -277.0        |
| Өмнөх үеийн үр дүн               |                |                |               |
| Тайлант үеийн үр дүн             |                |                |               |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 310.7          | 310.7          | 0.00          |
| <b>Дүн</b>                       | <b>3,084.3</b> | <b>2,807.3</b> | <b>-277.0</b> |

*Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,807.3 сая төгрөг болж 277.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

Өндөрхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн сумын төсөв тодотгон батлах тухай 07/01 дүгээр тогтоолоор Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 844.5 сая төгрөгийн орлого сумын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 836.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 7.6 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар дутуу биелүүлсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 12.6 сая төгрөгийн 2 алдаа илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

#### Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар:

- Тамгын газрын бараа материалын тайлангийн мал амьтад дансанд бүртгэлтэй Герефорд үйлдвэрийн 11.9 сая төгрөгийн 3 бухыг нас дэвшилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх” 5.1.5 дэх заалтад “Хэмжигдэхүйц байх”, 14.4.7 дахь заалтад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул нас дэвшилт хийж залруулга хийлгэсэн.
- Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд албан хаагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа даатгуулагчийн кодыг буруу сонгон тайлагнаж 0.7 сая төгрөгийг илүү шилжүүлснийг санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийсэн.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,556.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,556.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,351.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,715.8 сая төгрөгийг урсгал зардалд, 482.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 152.6 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 07/01 дүгээр тогтоолоор нийт зардлыг 205.6 сая төгрөгөөр бууруулан төсөвт тодотгол хийсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас нийт зардлын 171.8 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1,664.5 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 94.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас гүйцэтгэлээр 169.1 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1,682.0 сая төгрөгийг, үндсэн ажиллагааны орлогоос 89.5 сая төгрөгийг, нийт 1,940.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,077.4 сая төгрөг буюу 88.4 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 11.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11.5 сая, нийт 23.3 сая төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.6.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Өндөрхангай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2025 онд харьцуулалтын аргаар 8, шууд худалдан авалт 11, нийт 19 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

Тайлант онд огт хэрэгжээгүй 1 төсөл арга хэмжээ, дутуу хэрэгжсэн 1 төсөл, арга хэмжээ, төрийн сангийн зарлагын гүйлгээг хязгаарласантай холбоотой санхүүжилт дутуу олгосон 4 төсөл, арга хэмжээ байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,966.6 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 19.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 15.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,903.8 сая төгрөгийн 1 хувиар буюу 39.0 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 31.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өндөрхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 184 мэдээллээс хугацаандаа оруулсан 175, хугацаа хоцроосон 7 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Өндөрхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн аудиттай холбоотой албан шаардлага өгснийг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/124 дүгээр албан бичгээр биелэлтийг тайлагнан санхүүгийн аудитын fas.audit.mn цахим системд байршуулсан байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн засвар”-ын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн УВАӨХСЗДГ/20250602008 дугаартай гэрээгээр 2025 оны 08 дугаар сарын 10-ны дотор хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулан уг ажлын урьдчилгаа санхүүжилтийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр шилжүүлсэн байна. Тайлант онд тухайн компани гэрээний дагуу ажлаа хийж гүйцэтгээгүй тул орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд авлагаар тусган тайлагнасан байна.

Энэхүү авлагыг барагдуулсан эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Өндөрхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах асуудлыг анхаарч үзэхээр байна. Үүнд:

##### **Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар:**

- Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоонд байхгүй сантехникч, олон нийтийн байцаагч, хөдөөгийн багуудын манаач, сахиулыг ажиллуулж төсвөөс 45.8 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна. Энэ асуудлыг судалж шийдвэрлэсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзсэн.

#### **4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар**

Өндөрхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 3 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 1 төсвийн байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, 2 төсвийн байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 12.6 сая төгрөгийн 2 алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

### **Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл**

Хүснэгт 9.

/сая төгрөгөөр/

| Д/д         | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |             | Үүнээс    |             |               |     |                 |     |         |     |
|-------------|-------------------------------------|----------------------|-------------|-----------|-------------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|             |                                     |                      |             | Залруулга |             | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|             |                                     | Тоо                  | Дүн         | Тоо       | Дүн         | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1           | ЗДТГ                                | 2                    | 12.6        | 2         | 12.6        |               |     |                 |     |         |     |
| <b>Нийт</b> |                                     | <b>2</b>             | <b>12.6</b> | <b>2</b>  | <b>12.6</b> |               |     |                 |     |         |     |

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийцлийн аудитын асуудлын 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

### **5.3 Зөвлөмж**

#### **Илрүүлэлт:**

Өндөрхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолоор батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Сумын төвийн тохижилтын ажил” нэртэй 3 төсөл, арга хэмжээ, “Цэцэрлэгт хүрээлэнг засварлах” 1 төсөл, арга хэмжээг он дамжуулан тайлант онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 07/01 тоот “Сумын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор дараах 4 төсөл, арга хэмжээг он дамжуулан шилжүүлэн баталсан байна. Үүнд:

- Сумын төвийн тохижилтын ажил-35.9 сая төгрөг
- Сумын төвийн тохижилтын ажил-6.8 сая төгрөг
- Сумын төвийн тохижилтын ажил-3.6 сая төгрөг
- Цэцэрлэгт хүрээлэнг засварлах-1.6 сая төгрөг

Дээрх он дамжсан 4 төсөл, арга хэмжээг дараах компаниуд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд:

- Сумын төвийн тохижилтын 119.8 сая төгрөгийн ажлыг “Бэст Вүүдэн Хаус” ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 05 дугаартай гэрээ байгуулсан байна. Гэрээний 3.1-д “Гүйцэтгэгч нь “Сумын төвийг тохижуулах” ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр бүрэн хийж гүйцэтгэж ажлын хэсэгт хүлээлгэн өгнө” гэж заасан ч ажлыг бүрэн гүйцэтгээгүй тул хүлээн аваагүй байна.
- Сумын төвийн тохижилтын 68.0 сая төгрөгийн ажлыг “Ус-Инженеринг” ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр УВАӨХСЗДТГ/202312001 дугаартай гэрээ байгуулсан байна. Гэрээний 4.2-т “Гүйцэтгэгч нь “Сумын төвийг тохижуулах” ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэл хугацаанд 100 хувь гүйцэтгэж ажлыг хүлээлгэн өгнө” гэж заасан ч ажлыг бүрэн гүйцэтгээгүй тул хүлээн аваагүй байна.
- Сумын төвийн тохижилтын 74.5 сая төгрөгийн ажлыг “Болд тинкер” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 08 дугаартай гэрээ байгуулсан байна. Гэрээний 4.4-т “Гүйцэтгэгч нь “Сумын төвийн тохижилт”-ын ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд 100 хувь гүйцэтгэж ажлыг хүлээлгэн өгнө”, мөн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 08 дугаартай гэрээний хугацааг сунгах нэмэлт гэрээ байгуулан ажилласан байна. Тус гэрээний 1.3-т “Энэхүү гэрээний хүрээнд “Сумын төвийн тохижилт”-ын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор 100 хувь гүйцэтгэж хүлээлгэн өгнө гэж заасан. “Болд Тинкер” ХХК-аас гэрээний хугацааг сунгуулахаар ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаартай албан хүсэлтийн дагуу харилцан тохиролцож Гүйцэтгэгч нь уг ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны дотор гүйцэтгэж, ажлын хэсэгт хүлээлгэн өгнө гэж өөрчилж байна” гэж заасан ч ажлыг бүрэн гүйцэтгээгүй тул хүлээн аваагүй байна.

- Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилтын 27.4 сая төгрөгийн ажлыг “Болд тинкер” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06 дугаартай гэрээ байгуулсан байна. Гэрээний 4.4-т “Гүйцэтгэгч нь “Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилт”-ын ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд 100 хувь гүйцэтгэж ажлыг хүлээлгэн өгнө”, мөн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 06 дугаартай гэрээний хугацааг сунгах нэмэлт гэрээ байгуулсан байна. Тус гэрээний 1.3-т “Энэхүү гэрээний хүрээнд “Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилт”-ын ажлыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор 100 хувь гүйцэтгэж хүлээлгэн өгнө гэж заасан байна. “Болд Тинкер” ХХК-аас гэрээний хугацааг сунгуулахаар ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаартай албан хүсэлтийн дагуу харилцан тохиролцож гүйцэтгэгч нь уг ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны дотор гүйцэтгэж, ажлын хэсэгт хүлээлгэн өгнө гэж өөрчилж байна” гэж заасан ч ажлыг бүрэн гүйцэтгээгүй тул хүлээн аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь заалтад “Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна”, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно”, 40.1.1 дэх заалтад “Захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах”, 40.2 дэх хэсэгт “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно”, 40.2.1 дэх заалтад “Энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах” 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна”, 48.2 дахь хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ” 48.2.7 дахь заалтад “Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 11.1-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Гэрээний хугацаанд хийж дуусаагүй дээрх 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан гүйцэтгэгчээр хийлгэж хүлээн авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |     | Зөвлөмж |     |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
|                   |            |     |                                   |     |                          |     | Залруулсан |     | Залруулаагүй |     |         |     |
|                   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Дүн               |            |     |                                   |     |                          |     |            |     |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Үүнээс  |     |                                      |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|                    |             |     |               |     |                 |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     |   |     |
|                    | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Дүн                |             |     |               |     |                 |     |         |     |                                      |                     |   |     |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |            | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Үүнээс  |     |     |            |  |
|--|-------------|------------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|-----|------------|--|
|  |             |            |               |     |                 |     | Зөвлөмж |     |     |            |  |
|  | Тоо         | Дүн        | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо | Дүн        |  |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |            |               |     |                 |     |         |     |     |            |  |
| Дүн  |             |            |               |     |                 |     |         |     |     |            |  |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |            |               |     |                 |     |         |     |     |            |  |
| Өндөрхангай сумын ОНХС                                   | 1           | 0.0        |               |     |                 |     |         |     | 1   | 0.0        |  |
| Дүн  | 1           | 0.0        |               |     |                 |     |         |     | 1   | 0.0        |  |
| <b>Нийт дүн</b>  | <b>1</b>    | <b>0.0</b> |               |     |                 |     |         |     |     | <b>0.0</b> |  |

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.БАТСҮХ/

2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр